

МОНГОЛ -БНСУ-ЫН БАГШ СОЛИЛЦООНЫ ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн товч танилцуулга

БНСУ-ын Боловсролын яам “Ази-Номхон далайн бүсийн багш солилцооны хөтөлбөр”-ийг удирдлага зохион байгуулалтаар хангадаг бөгөөд тус хөтөлбөрт Монгол, Филиппин, Вьетнам, Тайланд, Индонез, Малайз, Камбодж зэрэг улс хамрагддаг. Тус улсын сургуулиудад Солонгос багш нарыг илгээх, мөн улсуудаас багш нарыг БНСУ-ын сургуулиудад зочин багшаар урьж 3 сарын хугацаанд сургалт- туршлага судлан ажиллах боломж олгодог хөтөлбөр юм.

“Ази-Номхон далайн бүсийн багш солилцооны хөтөлбөр”-ийн гол зорилго нь “Тогтвортой хөгжлийн боловсролын дэлхий нийтийн үйлийн хөтөлбөр, “Тогтвортой хөгжлийн зорилго 4-Боловсрол 2030” үйлийн хүрээ:

- 4.7 буюу “2030 он гэхэд бүх суралцагчид боловсролоор дамжуулан тогтвортой хөгжлийг дэмжихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг, чадварыг, тухайлбал, тогтвортой хөгжил, тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдал, энх тайван, хүчирхийллийг үл дэмжих, дэлхийн иргэн байх, тогтвортой хөгжилд соёлын оруулж буй хувь нэмэр, соёлын олон төрөл, зүйлд эерэгээр хандах зэрэг хандлагад суралцсан байх”;
- 4.с буюу “2030 он гэхэд хөгжиж буй орнууд, ялангуяа буурай хөгжилтэй, жижиг арлын орнуудын багш нарыг бэлтгэхэд олон улсын хамтын ажиллагааг дэмжих замаар мэргэшсэн багш нарын тоог нэмэгдүүлнэ” гэсэн зорилгын хэрэгжилтэнд дэмжлэг үзүүлэхэд оршиж байна.

Багш солилцооны хөтөлбөр 2012 оноос хойш жил бүр тасралтгүй амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд дээрх зорилгын хүрээнд Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос улс хоорондын найрамдалт харилцаа, боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагаанд хувь нэмэр оруулах, багшийн нарын мэдлэг, үр чадварыг сайжруулж, багшийн хөгжлийг дэмжих сургалт-туршлага судлуулах үйл ажиллагааг голлон зохион байгуулдаг.

Хөтөлбөрт оролцогч талууд:

- Санхүүжүүлэгч: БНСУ-ын Боловсролын яам
- Зохион байгуулагч: БНСУ-ын Боловсролын яам, Монгол улсын БСШУСЯ
- Хэрэгжүүлэгч: ЮНЕСКО-н Ази Номхон далайн олон улсын ойлголцлын боловсролын төв /ЮНЕСКО- АПСЕЮ/, Монгол улсын Багшийн Мэргэжил Дээшлүүлэх Институт
- Солилцооны хөтөлбөрийн багш нарыг хүлээж авах сургууль / 2 улсын /

Тэтгэлгийн хэмжээ

Хөтөлбөрт хамрагдах багш нарын онгоцны тийз (анх явахад 1удаа, буцахад 1 удаа), багш нарын сургалтын болон байрны төлбөр, эрүүл мэндийн даатгалын төлбөрийг хариуцаж, сар бүр амьжиргааны тэтгэлэг олгох ба тэтгэлгийн хугацаа 3 сар байна.

Шалгуур үзүүлэлт

Солилцооны хөтөлбөрийн хугацаа: *(Жил бүр 2 талын гэрээний дагуу хугацаа тодорхой болохоор зарлагддаг, 2 улсын хичээлийн жилийн бүтэц, тухайн жилийн үйл ажиллагаанаас хамаарч багшийн тоо, хөтөлбөрийн хэрэгжих хугацаа тодорхой болж аймаг, дүүргүүдэд албан бичгээр мэдээлэл хүргэгддэг)*

Тэтгэлгийн хугацаа	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	3 сарын хугацаатай сургалт-туршлага судлах үйл ажиллагаа
Шалгуур үзүүлэлт	<p>Сонгон шалгаруулалтанд оролцох багш нь доорх шаардлага, шалгуурыг хангасан байх;</p> <ol style="list-style-type: none"> 1. Багшлах эрхтэй байх 2. 5-аас дээш жил багшилж буй туршлагатай байх 3. Сүүлийн жилүүдэд БНСУ-аас 1 сараас дээш хугацаагаар ямар нэг тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдаагүй байх 4. Англи хэлний мэдлэгтэй байх 5. Эрүүл мэндийн хувьд асуудалгүй байх 6. Виз авах шаардлагыг хангасан байх 7. 45–аас доош настай байх 8. Багшлах заах арга, ур чадвар өндөртэй байх 9. Сургууль, бүс нутаг, үндэсний хэмжээнд тодорхой амжилт үзүүлсэн байх 10. Бүтээлч, хариуцлагатай, санаачилгатай байх 11. Багаар ажиллах чадвартай байх /Бусдын өмнөөс хариуцлага хүлээх чадвартай, бусдад эергээр нөлөө үзүүлдэг байх / 12. Багшийн ёс зүйтэй, соёлтой байх /Эерэг хандлага, харилцаатай байх/ 13. Монгол улсаа төлөөлж хөтөлбөрт оролцох мэдлэг, чадвар, туршлагатайг хамт олны хурлаар хэлэлцсэн байх 14. Хөтөлбөрт хамрагдаж ирээд орон нутаг, бүс, үндэсний түвшинд багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, манлайлах, нөлөөлөх, арга туршлагаа хуваалцах 	

Сонгон шалгаруулалтын үйл явц

1



Хугацаа тодорхой болсон үед албан бичгээр мэдэгдэх (www.itpd.mn цахим хуусаар Аймаг нийслэлийн БСУГ болон дүүргийн хэлтэст албан бичиг хүргүүлнэ.)

2



Аймаг, Нийслэлийн БСУГ, дүүргийн БХ-үүд шаардлага хангасан 1 багшийг нэр дэвшүүлж, холбогдох материалыг бүрдүүлж БМДИ-д хүргүүлнэ.

3



Нэр дэвшигчдийн бүрдүүлсэн материалыг БСШУСЯ болон БМДИ-ийн төлөөлөл бүхий бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг үзэж магадална. Материал нь тэнцсэн багш нартаа ярилцлага хийнэ. БСШУСЯ болон БМДИ-ийн цахим хуудаст хөтөлбөрт хамрагдах шаардлага, шалгуур хангасан багш нарын нэрсийг байршуулна.

4



Ярилцлагад тэнцсэн багш нарыг чиглэл өгөх сургалтад хамруулж, солилцооны хөтөлбөрт оролцох эрх олгоно. /Энэ үед виз болон холбогдох материал бүрдүүлэлтийг тухайн хүний хамт БМДИ хамтран зохион байгуулна.